

СЭТГҮҮЛЧИЙН НИЙГМИЙН ҮҮРГИЙН ТУХАЙ ЗАРИМ АСУУДАЛ

М. Одмандах *

* МУБИС-ийн Утга зохиолын тэнхмийн багш, хэлбичгийн ухааны доктор (PhD)

Түлхүүр үг: сэтгүүлчийн нийгмийн үүрэг, олон нийтийн санал асуулга, иргэний сэтгүүл зүйн зарчим.

Сүүлийн хэдэн жилд манай сэтгүүлчдийн эрж хайж, тэмцэж, хүртэж ирсэн зүйл бол "эрх чөлөө" юм. Эрх чөлөө гэдэг бол маш өргөн ойлголт. Өдөр тутмын ахуй амьдралд "дур зоргоороо байх", "ямар ч саад бэрхшээлгүй байх", "чөлөөт цаг албадлагагүй байх", "үүрэг зорилгогүй байх" зэрэг утгыг илэрхийлдэг бол нийгмийн амьдралд "ямар нэгэн шахалт дарамтгүй байх", "хавчлага мөлжлөгөөс ангид байх", "аливаа хяналт, мөрдлөг хорилтын гадуур байх" гэсэн утгатай ажээ. Тэгвэл сэтгүүл зүйн, сэтгүүлчийн эрх чөлөө гэдэгт "мэдээлэл олж авах эрх зүйн орчин баталгаатай байх", "ажлын орчин нөхцөл хангагдсан", "үзэл бодлын хяналт байхгүй", "эрх чөлөөтэй хэвлэн нийтлэх" гэх зэргээр ойлгогддог.

Гэхдээ энэ бүх эрх чөлөөний цаад мөн чанар нь "үүрэг хариуцлага"-аа ухамсарлах явдал. Энэхүү үүрэг хариуцлагаа ухамсарлахгүйгээр эрх чөлөөний тухай ярих боломж байхгүй. Бид эрх чөлөөг хэдий хэмжээгээр эдлэхийг хүснэв, тэр хэмжээгээрээ

ажил үүрэгтээ хариуцлагатай хандах ёстой.

Олон нийтийн санал асуулгаар судалгаанд оролцогчдын дийлэнх олонх, мөн сэтгүүлчид ч өөрсдийгөө "сэтгүүлч нийгэм орчиндоо их нэр хүндтэй, нөлөөтэй хүмүүс" гэж үздэг. Судалгаанд оролцогчдын 16.42 хувь нь багш, эмч, хуульч, инженер, эдийн засагч мэргэжлийн хүмүүстэй харьцуулахад сэтгүүлчид нийгэмд "хамгийн нөлөөтэй эрх мэдэлтэй" гэсэн бол, 20 хувь нь эрх мэдлийн хувьд "дээрээсээ хоёрт", 19.37 хувь нь "гуравт" орно гэжээ. Тиймээс сэтгүүл зүй, сэтгүүлчийн нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага өндөр байна гэсэн үг.

Гадаад, дотоодын олон эрдэмтэд, судлаачид сэтгүүл зүйн үүргийн тухай онолын төвшинд судалж, тайлбарлаж, өөрсдийн ангиллуудыг хийсэн байдаг. Тэд өөр өөр нэр томьёо хэрэглэдэг боловч үндсэн суурь ойлголт, үзэл баримтлал нь ижил байна. МУИС-ийн багш, доктор, профессор М.Зулькафиль үүргийг дор дурдсан байдлаар ангилсан байна. Үүнд:

- мэдээлэгч, танин мэдүүлэгч, удирдлагын хэрэгсэл болгогч, зохион байгуулагч, харилцааны, зугаацан цэнгээх хэрэгсэл болох үндсэн

үүргүүдийн хамт гэгээрүүлэгч, хүмүүжүүлэх, нийгмийн санаа бодлыг төлөвшүүлэх, хяналтын хэрэгсэл болгох зэрэг нэмэлт үүргүүдийг гүйцэтгэж байна¹ гэж үзсэн байна.

Ялангуяа чөлөөт хэвлэл, ардчилал дахь сэтгүүл зүйн үүргийн тухай олон эрдэмтэд өөрсдийн үзэл баримтлалыг дэвшүүлсэн байдаг. Тухайлбал Германы судлаачдын тодорхойлсноор Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь хоорондоо нягт холбоотой үндсэн гурван үүргийг ардчилсан нийгэмд гүйцэтгэдэг гэж үзсэн байдаг.

Энэ нь:

1. Иргэдийг мэдээллээр хангах,
2. Олон нийтийн үзэл бодлыг бүрдүүлэхэд нөлөө үзүүлэх,
3. Шүүмжлэх, хяналт тавих юм.

Мөн АНУ-ын Вандербилтын их сургуулийн профессор Честер Е. Фений судалгаанаас үзэхэд ардчилсан нийгэмд хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь дараах үүрэгтэй байна. Үүнд:

1. Мэдээлэх,
2. Сурган гэгээрүүлэх,
3. Засгийн газрын болон бусад томоохон байгууллагуудын үйл ажиллагааг хянах,
4. Хэлэлцэх асуудлын төслийг гаргах, олон нийтийн санаа бодлыг бүрдүүлэхэд нөлөөлөх зэрэг үүргийг биелүүлдэг² гэж үзжээ.

Дээрх судлаачдын үзэл баримтлалыг харахад зарим нэр томъёоны хувьд ялимгүй зөрж байгаа боловч

бидний хүлээн зөвшөөрдөг үүргүүдтэй адил байгааг анзаарч байгаа байх.

Судлаачдаас гадна үзэгч, сонсогч, уншигчид ч гэсэн сэтгүүл зүйн нийгмийн үүргийг тодорхойлсон байна. "Сонины нийтлэл ба олон нийтийн санаа бодол" социологийн судлагааны дүнгээс үзэхэд, уншигчдын 76.4% (254) "мэдээлэх", 68.3% (220 хүн) "танин мэдүүлэх" 64.3% (207 хүн) "нийгмийн чухал асуудалд олон нийтийн санаа бодлыг

төвлөрүүлэх" нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн гол үүрэг гэсэн байна. Зөвхөн 25 уншигч "зугаацуулан цэнгээх" үүрэгтэй гэсэн байна. Судалгаанд оролцогчдын боловсролын төвшин ахих тутам тэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн "мэдээлэх", "танин мэдүүлэх" үүргийг чухал

«

Социологийн судлагааны дүнгээс үзэхэд, уншигчдын 76.4% "мэдээлэх", 68.3% "танин мэдүүлэх" 64.3% "нийгмийн чухал асуудалд олон нийтийн санаа бодлыг төвлөрүүлэх" нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн гол үүрэг гэсэн байна.

»

хэмээн үздэг нь харагдаж байна.

Европын өргөн мэдээллийн хэрэгслийн бодлогын асуудлаар сайд нарын хэмжээнд болсон 4-р бага хуралд оролцогсад дараах зарчмыг хэлэлцэн тохирч баталсан байна. Түүний Нэгдүгээр зарчимд:

Жинхэнэ ардчилал нь чөлөөтэй, бие даасан, олон ургалч үзэлд тулгуурласан, хариуцлага бүхий сэтгүүл зүй оршин тогтнох, хүч чадлыг нь бэхжүүлэх нөхцөл шаарддаг. Ардчилсан нийгмийг хөгжүүлэхэд оруулах сэтгүүл зүй, сэтгүүлчийн үүрэг оролцоо их гэдэг нь дээрх судалгаа болон бусад зүйлээс харагдаж байна. Энэ нөхцөлд сэтгүүл зүй нь:

• Олон нийтийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагааны тухай хүмүүст мэдээлж, ингэснээр нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх бололцоо олгоно,

• Хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүст үзэл бодлоо илэрхийлэх бололцоо олгох, олон нийтийн болон нийгмийн санаа бодлыг тодорхойлон, түүний тухай мэдээлэх үүрэгтэй гэж заасан байна.

Мөн цааш нь Гуравдугаар зарчимд: "Сэтгүүл зүй нь доорхи нөхцөл бүрдсэн тохиолдолд жинхэнэ ардчиллыг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмрээ оруулна. Үүнд:

1. Сэтгүүлчийн мэргэжил эзэмшихэд ямарваа хязгаарлалт тогтоохгүй,

2. Улс төрийн хүчин болон хэсэг бүлэг хүмүүс, засаг захиргааны хувьд төлөөлөгчдийн өмнө хэвлэн нийтлэгчдийн хувьд бүрэн бие даасан байдалтай байх,

3. Засаг захиргааныханд байгаа мэдээллийг авч үнэн шударгаар хэнд ч ая тал засахгүйгээр дамжуулах,

4. Мэдээллийн эх сурвалжийг нууцлан хамгаалах" гэж заасан нь сэтгүүлч хүн үүргээ биелүүлэхэд нийгмийн зүгээс сэтгүүл зүйг хөгжүүлэхэд нөхцөл бололцоо хангасан байх нь чухал гэсэн санаа юм.

Тийм учраас жинхэнэ ардчиллын нөхцөлд сэтгүүл зүйн үндсэн үүрэг нь тухайн салбарт ажиллагсад (сэтгүүлчид) хариуцлагаа ухамсарлан, мэргэжлийн ёс зүйг сахин өөрийн бие даасан байдал, шүүмжлэлт байр сууриа алдахгүй байхад оршдог байна. Үүний тулд *сэтгүүлчид нь иргэдийг эрхээ эдэлж, үүргээ биелүүлж, хариуцлагатай байхад нь хэрэгтэй, шаардлагатай мэдээллээр хангаж үл*

чадвал ардчилал жинхэнэ утгаараа хөгжих боломжгүй юм.

Энэ бүхнээс авч үзвэл сэтгүүлчийн нийгмийн өмнө хүлээх үүргийг тусгайлан авч үзэх шаардлага зүй ёсоор гарч ирж байгаа юм. Энэ талаарх олон түмний санаа бодлыг тэндах зорилгоор *"Сонины нийтлэл ба олон нийтийн санаа бодол"* судалгаанд асуулга оруулсан байна.

Судалгаанд оролцогсдын 93.2 хувь нь (300 хүн) *"олон нийтийг үнэн бодит мэдээллээр хангах нь сэтгүүлчдийн нийгмийн гол үүрэг"* гэж үзсэн байна. Мөн л судалгаанд оролцогчдын боловсролын төвшин ахих тусам энэ үүргийг голлосон байна. Дээрх судалгаанд оролцогчдын боловсрол, мэргэжил, оршин суугаа газар нутаг өөр боловч тэд *"шударга ёс, үнэний төлөө тэмцэхийг эрмэлзэх", "төр засгийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагааг мэдээлэх замаар олон нийтийн хяналтыг бий болгох", "нийгмийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэх"* нь сэтгүүлч хүний нийгмийн гол үүрэг гэж үзсэн байна. Мөн *"Сонины нийтлэл ба олон нийтийн санаа бодол"* судалгаанд оролцогчдын олонх буюу 192 хүн (59.6 хувь) *"нийгмийн хурц асуудлыг хөндөж, түүнийг шийдвэрлэхэд төр засгийн анхаарлыг хандуулах"*, 175 хүн (54.3 хувь) *"нийгмийн ач холбогдолтой мэдээлэл түгээх"* нь сэтгүүлчийн нийгмийн гол үүрэг гэж үзжээ.

Уншигч олон түмэн ямагт үнэнийг мэдэхийг хүсдэг учраас *"үнэн бодитой мэдээллийг уншигч олон түмэнд хүргэх", "шударга ёс, үнэий төлөө тэмцэхийг эрмэлзэх"* нь сэтгүүлч хүний нийгмийн гол үүрэг хэмээн санал

нэгтэй "тодорхойлсон" байна. Сэтгүүлчид өөрсдийн үүргээ хэрхэн ухамсарлаж, хэрхэн биелүүлж байгаа нь өнөөдөр бас ч гэж эргэж бодмоор зүйлийн нэг мөн.

Бид нийгмийн дээрх үүргээ ухамсарлаж чадаагүйгээс, өөрийн ажилд хайнга хандсанаас, мэдлэг боловсрол, хууль эрх зүйн мэдлэгээ байнга дээшлүүлээгүйгээс Хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан, гүтгэсэн хэрэг маргааныг шүүхээр шийдсэн хэрэг сүүлийн хэдэн жилд олон гарсан байна. Энэ талын судалгааг "Глоб интернэйшнл" ТББ, МННХ-Соросын сангийн санхүүжилтээр 2001 оны 12-р сард нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд хийсэн байна. Энэхүү судалгаагаар 1999-2001 он дуусталх гурван жилийн байдлаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр хувь хүн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан тухай иргэний маргаан 79, "гүтгэлгийг хэвлэл мэдээллийн буюу бусад аргаар олшруулан тараасан" гэмт хэрэг 4, бүгд 83 хэрэг маргааныг шийдвэрлэсэн байна.

Энэхүү 79 иргэний хэргийн 47 хэрэгт шүүх хариуцагчаар татагдан орсон Хэвлэл мэдээллийн хэрэгслийг бусдын нэр төр, алдар хүндийг хэвлэлээр дамжуулан гутаасан гэм буруутай гэж тогтоосон байна. Энэ нь нийт иргэний хэргийн 59.4 хувь байгаа бөгөөд эдгээр хэргийн 29.1 хувь буюу 23 хэрэгт хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэм буруутайгаа хүлээн зөвшөөрч эвлэрсэн байна.

Мөн хугацаанд шүүх хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан гүтгэлгийн дөрвөн эрүүгийн хэргийг шийдвэрлэсэн нь 6 дүүргийн шүүхийн

шийдвэрлэсэн эрүү, иргэний хэрэг, маргааны 4.8 хувь байна. Тэр 4 хэрэгт 6 сэтгүүлчийг гэм буруутайд тооцон эрүүгийн хуульд зааснаар ял шийтгэжээ. Судалгааны хугацаанд эрүүгийн хэрэгт хорих ял шийтгүүлсэн нэг сэтгүүлч байсан бөгөөд түүнд оноосон хорих ялыг тэнсэж хянан харгалзах хугацаа тогтоожээ. Харин 2002 оны 9-р сарын 1-нд хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн эрүүгийн хуулийн дагуу 2 сэтгүүлчийг ийм хэргээр шоронд хорьсон бөгөөд мөн одоогийн байдлаар 6 сэтгүүлчид эрүүгийн хэрэг үүсгээд шалгаж байгаа нь сэтгэл эмзэглүүлэхгүй байхын аргагүй.

Мөн "газрыг шударгаар хувьчлахын төлөө хөдөлгөөн"-ий үйл ажиллагааг сурвалжилж ажил үүргээ гүйцэтгэж явсан 4 сэтгүүлч, 2 операторчийг баривчлан, зөвшөөрөлгүйгээр биед нь үзлэг хийн, техник хэрэгслийг нь хурааж хорьж саатуулсан байдаг. Энэ бүх баримт нь сэтгүүлч бидэнд сургамж болох зүйл бөгөөд цаашид бид ажил үүргээ гүйцэтгэхдээ мэргэжлийн өндөр төшинд ажиллахгүй бол хуулийн хатуу заалт цаана чинь бий шүү гэдгийг сануулах гэсэн хэрэг.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь үзэл бодлын чөлөөт индэр болохын хувьд нийгэмд бугшиж буй аливаа бусармаг явдлыг илчлэн олны сонорт хүргэж нийгэмд шүүмжлэлт, эрүүл саруул уур амьсгалыг бий болгохын төлөө тэмцдэг. Ингэхдээ сэтгүүлч хүн өөрийн үүргийг гүнээ ухамсарлаж, мэргэжлийн ёс зүйн алдааг гаргахгүй, үнэн бодит мэдээллийг хүргэхийг эрмэлзэх нь дээрх байдалд хүргэхгүй байх үндсэн нөхцөл байх болно.

Дээр дурдсан судалгаа баримтаас үзэхэд сэтгүүлч нь ардчилсан нийгэмд дараах үүргийг гүйцэтгэж байна гэж үзэх үндэстэй байна. Үүнд:

Сэтгүүлчийн нийгмийн үүрэг нь:

1. Олон нийтийг үнэн бодит мэдээллээр хангах,
2. Шударга ёс, үнэний төлөө тэмцэхийг эрмэлзэх,
3. Нийгмийн хурц асуудлыг хөндөж, түүнийг шийдвэрлэхэд төр засгийн анхаарлыг хандуулах,

4. Нийгмийн ач холбогдолтой мэдээлэл түгээх,

5. Төр засгийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагааг мэдээлэх замаар олон нийтийн хяналтыг бий болгох нь гол үүрэг юм.

Мөн дээрх үүргүүдээс гадна ардчилсан нийгмийг хөгжүүлэхэд түүний онолын ойлголт болон бусад ойлголтуудыг ард түмэнд үнэн зөвөөр хүргэх нь эрүүл саруул уур амьсгалыг нийгэмд төлөвшүүлэхэд гол нөлөө үзүүлж чадна.

Үүнд:

1. Ардчилсан нийгэм, иргэний нийгмийн тухай ойлголтыг үнэн зөвөөр хүргэж, ард түмэн, олон нийтийг иргэний эрхээ эдлэхэд ухаалгаар ханддаг болгоход туслах,

2. Иргэдийн ухамсар, идэвхийг сэргээснээр өөрсдөдөө хамаатай асуудлыг төр засгийн анхааралд хүргэж шийдвэрлүүлэх боломж олгох,

3. Иргэний сэтгүүл зүйн зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөж, амьд

сонирхолтой шинэ сэтгүүл зүйн чиглэлийг хөгжүүлэхийн төлөө ажиллах хэрэгтэй байна.

Энэ бүх үүргийг яв цав гүйцэтгэхэд сэтгүүлч бидэнд мэргэжлийн өндөр ур чадвар, цаг үргэлж өөрсдийн боловсрол, мэдлэг, нийгэмд нөлөөлөх өөрийн боломжийг байнга дээшлүүлэх нь эн тэргүүний чухал зүйл.

Дүгнэлт

Цаашид бид сэтгүүлчийн нийгмийн үүргээ өндөр төвшинд хэрэгжүүлэхийн тулд дараах зүйлсийг анхаарах нь чухал гэж үзэж байна. Үүнд:

1. Сэтгүүлч мэргэжил, боловсролоо байнга дээшүүлж байхыг цаг үе шаардаж байна,

2. Сэтгүүлч хүн мэргэжлийн нэр хүнд, нэр төрөө хамгаалах, үүний тулд ёс зүйтэй байх,

3. Сэтгүүлч хүн ардчилал, хүний эрх, эрх чөлөө, иргэний нийгмийн тухай мэдлэг мэдээлэлтэй байх,

4. Сэтгүүлч өөрсдийн нийгмийн үүргийг биелүүлэхэд хэрэгтэй байж болох орчин нөхцлийг бүрдүүлэхийн тулд өөрийн хүч боломжоо дайчлан ажиллах,

5. Мэдээлэл олж авахтай холбогдсон Монгол улсын хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй байх, тэдгээр хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох,

6. Мэдээлэл хайх, олж авахдаа хувийн болон улс төр, бизнесийн зэрэг алив явцуу бүлгийнхний сонирхол, ашиг завшаан, атгаг санаархалд хэзээ

«

*Мэдээлэл хайх, олж авахдаа
хувийн болон улс төр,
бизнесийн зэрэг алив явцуу
бүлгийнхний сонирхол, ашиг
завшаан, атгаг санаархалд
хэзээ ч үл автах, гагцхүү
шударга ёс, үнэн мөнхийг
дээдлэх хэрэгтэй*

»

ч үл автах, гагцхүү шударга ёс, үнэн мөнийг дээдлэх,

7. Олж авсан мэдээллээ баримтжуулах, үнэн мөнийг нь сайтар магадлах, мэргэжлийн нийтлэг болон өвөрмөц арга барипаас суралцах,

8 Мэргэжлийн арга барил, ур чадвар эзэмшсэн байх, эл ажил хэрэгт нягт нямбай хандах зэрэг болно.

Сэтгүүлчид мэргэжлийн алдаа гаргалгүй, ажил үүргээ ур чадварын өндөр төвшинд, нэр төртэй биелүүлэх, үнэн мэдээллээр хангах үндсэн үүргээ биелүүлэхэд тустай байх болов уу. Ингэснээр иргэний ардчилсан чөлөөт нийгмийг хөгжүүлэхэд сэтгүүлчдийн оруулах хувь нэмэр, оролцоо өндөр болж нийгмийг идэвхтэй хөдөлгөөнд оруулж чадна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. В о р о ш и л о в В. В. 2002. Журналистика. СПб.
2. З у л ь к а ф и л ь М. 2004. Сэтгүүл зүйн онолын үндэс.
3. П р о х о р о в Е. П. 2000. Демократия и журналистика. Москва.
4. Б е с п а л о в А. Г. и др. 2002. История мировой журналистики. Ростов-на-Дону.

5. S t r a u b h a a r, L a R o s e. 2000. Media Now. Communications Media in Information Age. Wadsworth.
6. S t a n l e y G. B a r a n, D e n n i s K. D e v i s. 2000. Mass Communication Theory. Wadsworth.
7. F u l l e r J a c k. 1996. News values. Ideas for an Information Age. Chicago.

Ишлэл

¹ З у л ь к а ф и л ь М. 2004. Сэтгүүл зүйн онолын үндэс. 146-187 дахь тал.

² Ишлэлийг: мөн тэнд, 286 дахь тал.

Резюме

В данной статье сделана попытка рассмотреть одно из основных теоретических понятий о функции журналистики в тесной связи с обществом и современностью. Представлены свои объяснения о том, что журналистика, как общественный институт, должна отражать изменения, влияние и точку зрения современности и отвечать духовной потребности читателей, также особо отмечена важность твердо придерживаться функций, которые ставятся перед журналистикой и журналистами Монголии.